



АРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 5/41

Эрдэнэбулган сум

Төрийн зарим албан хаагчдад
орон нутгийн нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5 дахь хэсгүүд, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.17 дахь хэсэг, Засгийн газрын 2023 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт, 2024 оны 82 дугаар тогтоолын хавсралт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 08 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын тамгын газрын төрийн улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчдад олгох орон нутгийн нэмэгдлийг нэгдүгээр хавсралтаар, төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчдад олгох орон нутгийн нэмэгдлийг хоёрдугаар хавсралтаар, төрийн мэргэжлийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчдад олгох орон нутгийн нэмэгдлийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хавсралтад нэр дурдагдсан албан тушаал эрхэлдэг албан хаагчдад олгох орон нутгийн нэмэгдлийг тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн хувиар тооцож, 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгохыг аймгийн Засаг даргын тамгын газрын ахлах нягтлан бодогч (В.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ГОМБОДОРЖ

